

"ЦАХИМ МОНГОЛ" ҮНДСЭНИЙ ХӨТӨЛБӨР

1. Энэхүү хөтөлбөр нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (цаашид "МХХТ" гэх)-ийн салбарт төрөөс баримтлах дүнд хугацааны (2005-2012 он) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

Дэлхийн улс орнуудад аж үйлдвэржсэн эринээс мэдээлэлжсэн эринд шилжих үйл явц улам эрчимжин мэдлэгт тулгуурласан нийгмийг цогцлон байгуулж нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөнөөр нэвтрүүлэн хэрэглэж байна.

Монгол Улсын хувьд МХХТ-ийн давуу хэрэглээг бүрдүүлж, түүнийг хөгжлийн хурдасгуур болгон мэдлэгт тулгуурласан нийгмийг байгуулах, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгох шаардлага зүй ёсоор урган гарсан юм. Иймээс Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, МХХТ-ийн хөгжилд өндөр ач холбогдол өгч олон шинэлэг зорилтуудыг дэвшүүлэн тавьсан болно.

2. Хөтөлбөрийн үндэслэл

Улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд МХХТ-ийг бүтээлчээр нэвтрүүлэх, төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, мэдээллийн найдвартай тогтолцоо бий болгох, мэдээлэлжсэн нийгмийг байгуулах, мэдээлэлжүүлэлтийн хоцрогдлыг багасгах, МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл хүртэх тэгш бус байдал, тоон ялгааг арилгах, салбарын эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлэх шаардлага тавигдаж байна.

Дэлхийн ихэнх улс орон өнгөрсөн зууны сүүлчээс эхлэн МХХТ-ийг хөгжүүлэх урт, богино хугацааны стратеги хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, төрийн удирдлага, үйлчилгээ, үйл ажиллагаанд МХХТ-ийг өргөн ашиглан шинэ төрлийн хэрэгтэй бий болгоход зарцуулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна.

Дэлхийн олон орон холбоо, мэдээллийн дэд бүтцийг бий болгох үндэсний хөтөлбөрийг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Сингапурын "Ухаалаг арал" хөтөлбөр, БНСУ-ын "Мэдээллийн дэд бүтэц" үндэсний төлөвлөгөө, Малайзын "Мультимедиа супер коридор" хөтөлбөр, Япон Улсын "Цахим Япон" зэрэг олон хөтөлбөрийг энд дурдаж болно. Эдгээр орнуудад хэрэгжсэн эхний хөтөлбөрүүд амжилттай болсон төдийгүй дараагийн шатыг хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгч төрийн бодлого, санхүүгийн дэмжлэгээ нэмэгдүүлсээр байна.

Өндөр хурдтай хөгжиж байгаа Азийн ихэнх орнуудын хөгжлийн гол түлхүүр нь МХХТ болж байна. Ялангуяа газар нутаг уудам, хүн ам сийрэг суурьшилтай, далайд гарцгүй манай орны хувьд МХХТ-ийн боломжийг түлхүү ашиглах нь нэн чухал юм. Мөн мэдлэгт тулгуурласан мэдээлэлжсэн нийгэм байгуулахад МХХТ-ийг нийгмийн бүх салбарт эрчимтэй нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм.

МХХТ-ийг тууштай нэвтрүүлэхэд дараахь хүчин зүйлс саад болж байна. Үүнд:

- Эрх зүй, зохицуулалтын механизмуд боловсронгуй болоогүй
- Төрийн байгууллагуудын удирдлагын шатанд МХХТ-ийн талаархи ойлголт цэгцтэй биш, ашиглалт хангалтгүй, нэгдсэн тогтолцоо бүрдээгүй
- Энэ салбарт хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлого бүрдээгүй
- МХХТ-ийн салбарын хүний нөөц дутагдалтай
- Харилцаа холбооны үндсэн сүлжээний хурд, багтаамж нь өнөөгийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах техник, технологи, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авагдаагүй
- Тоон ялгаа, мэдээллийн тэгш бус байдал буурахгүй байгаа
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, шинжлэх ухаан, урлаг, соёлын салбарт МХХТ-ийн хэрэгцээ сул хөгжсөн
- МХХТ улс даяар жигд нэвтрээгүй, орон нутагт МХХТ-ийн техник хангалт сул хийгдсэн зэрэг нөхцөлийг тус тус дурдаж болно.

Дээрх сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, улмаар мэдлэгт тулгуурласан эдийн засгийн шинэ орчин, шинэ чадавхийг бүрдүүлэх, МХХТ-ийг өргөн хэрэглээ болгоход энэхүү хөтөлбөр чиглэгдэнэ.

Төслийг боловсруулахад Мянганы хөгжлийн зорилтууд, Мэдээлэлжсэн нийгмийн талаархи дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаар баталсан Үйл ажиллагааны төлөвлөгөө болон Зарчмын тунхаглал зэрэг дэлхийн хэмжээний чухал арга хэмжээний дүнг анхаарсан болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь боломж бүрдэнэ. Үүнд:

- Бүх нийтийг өндөр хурдтай, хямд, хялбар ашиглаж болохуйц мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний дэд бүтцээр тэгш, зохистой байдлаар ханган мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангах
- Мэдлэгт тулгуурласан эдийн засгийн шинэ орчин, шинэ чадавхийг бий болгох замаар дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлж МХХТ-ийг эдийн засгийн тогтвортой өсөлт болон технологийн хөгжлийг дэмжих хөдөлгөгч хүч болгон ашиглах
- Олон нийтийн мэдээллийн нээлттэй орчинг бүрдүүлэх замаар улс төр, эдийн засаг, нийгэм, боловсрол, шинжлэх ухаан, урлаг, соёлын талаархи мэдээллийг хүртэх тэгш боломжийг бий болгох
- Өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудал авилгал, хүнд суртлыг арилгахад МХХТ-ийн давуу талыг ашиглах
- Мэдээллийн эрин зуунд Монгол Улсын нийгмийн үнэт зүйл болон түүх, соёлын өвийг хадгалах
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг бэхжүүлэхэд МХХТ-ийг ашиглах
- МХХТ-ийг хүний нөөцийг хөгжүүлэх болон чадавхийг дээшлүүлэхэд ашиглах, ялангуяа МХХТ-ийн боловсрол эзэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрэлт хэрэгцээнд тохирсон тусгай хөтөлбөрийг дэмжих
- Мэдээлэлжсэн нийгэм дэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн төрөл бүрийн сүлжээ, үйлчилгээг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо болон иргэний нийгмийн санал санаачилгад тулгуурлах

Олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлж үр дүнтэй төсөл, хөтөлбөр, харилцан ашигтай хөрөнгө оруулалтыг дэмжих.

3. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго нь Мэдээлэл, харилцаа холбооны технологийг XXI зууны хөгжлийн үндсэн хурдасгуур гэж үзэж, Монгол Улсад мэдлэгт тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг байгуулахад оршино.

Эдийн засгийн шинэ орчин, оюунлаг чадавхийг бий болгох, улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах замаар хүн амын амьдралын чанарыг сайжруулж, 2012 онд МХХТ-ийн хөгжлийн гол үзүүлэлтүүдээр Ази тивд эхний арван улсын тоонд орох зорилгыг энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн гол үзүүлэлтүүдийг дэлхийн цахилгаан холбооны байгууллагаас гаргадаг зөвлөмжид үндэслэн тодорхойлох, эдгээр үзүүлэлтэд хүрэхэд шаардлагатай санхүү, хууль эрх зүй, сургалт сурталчилгааны арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

4. Хөтөлбөрийн зорилтууд

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- МХХТ-ийг нэвтрүүлэх, хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох
- Улс орныг хамарсан нийтэд хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны нэгдсэн сүлжээ байгуулах
- Өндөр хурдны нэгдсэн сүлжээг олон улсын урсгалд холбох
- МХХТ-ийн салбарт бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжих
- Мэдээллийн бүх нийтийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх
- Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо (Integrated system), мэдээллийн нэгдсэн санг байгуулж "Төрийн ой" (Government institutional memory)-г бий болгох
- МХХТ-д тулгуурласан удирдлагын шинэ загварыг бий болгож цахим засаглалыг хэрэгжүүлэх
- Хүний эрхийг хамгаалах зорилгоор цахим ардчиллыг хөгжүүлэх санал, санаачилгыг дэмжих
- Цахим арилжааг ашиглан бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж эдийн засгийн шинэ орчинг бүрдүүлэх
- МХХТ-ийн ололт, амжилтыг эдийн засгийн салбарт нэвтрүүлж мэдлэгт тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Нийгмийн салбарт МХХТ-ийг нэвтрүүлж иргэдэд чиглэсэн, үр дүнтэй нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх
- МХХТ-ийг ашиглан хүний нөөцийг бүх шатанд бэлтгэх, хөгжүүлэх
- Бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх

- Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгох
- МХХТ-ийг иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, амьдралын хэв маягийг тодорхойлох чухал хүчин зүйл болгох
- Бүх нийтийг компьютержүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж 1000 хүнд ногдох компьютерийн тоог 2012 он гэхэд 100-д хүргэх .

5. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн өнөөгийн байдал

5.1. Бодлого зохицуулалт 2000 онд Улсын Их Хурлаас "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал", 2002 онд Засгийн газраас "Мэдээлэл холбооны технологийг дунд хугацаанд хөгжүүлэх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө"-г тус тус баталсан бөгөөд Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Патентийн тухай, Зохиогчийн эрхийн тухай, Оюуны өмчийг хамгаалах тухай, Технологи дамжуулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай зэрэг хуулиуд нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын үйл ажиллагааг зохицуулж байна.

Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2001 онд баталсны үндсэн дээр харилцаа холбооны салбарыг либеральчлах, шуударга өрсөлдөөнийг бий болгох, зохицуулалтын шинэ, бие даасан тогтолцоог бий болгож Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулан, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийг шинэ шатанд гаргах" гол зорилтыг тодорхойлсон юм. Энэхүү гол зорилтыг биелүүлэх арга хэмжээний хүрээнд:

- "Цахим Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Цахим засаглалыг нэвтрүүлснээр төрөөс иргэд, байгууллагад үзүүлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдийн зүгээс төр, засагт хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгох
- Улс орны хэмжээнд нэгдмэл кодчиллыг бий болгосноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх
- Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчлэн олон улсын өргөн зурвасын сүлжээнд нэгдэх
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн газрын сургууль, айл өрхийг компьютержүүлж, интернэтийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх
- Төвийн болон сэрэгдэх эрчим хүчинд холбогдсон сумын төв, суурин газрын мэдээлэл холбооны сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Программ хангамжийн эрэлтийг нэмэгдүүлж бүтээгдэхүүний өсөлтийг дэмжих
- Томоохон суурин газруудын автомат телефон станцыг тоон технологид үе шаттай шилжүүлнэ. Улсын хэмжээнд 100 хүнд ноогдох суурин болон хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2012 онд дунджаар 40-д хүргэх
- Интернет худалдаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношилгоог эрчимтэй нэвтрүүлэх
- Телевизийн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлснээр телевизийн олон сувгийг орон даяар үзэгд болох
- Гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаяжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх
- Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлэн шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлэх
- Улиастай-Улаангом-Мөрөн чиглэлийн тоон сүлжээг байгуулах
- Улаанбаатар-Дашинчилэн-Булган, Дашинчилэн-Арвайхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилж, Налайх-Багануурын дамжуулах сүлжээг өргөтгөх
- Хотын захын гэр хороолол, дагуул хотуудыг холбоожуулж, интернэтийн сүлжээг өргөтгөх зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

5.2 Дэд бүтэц

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ нь Улаанбаатар хот болон зарим аймгийн төвүүдийг холбосон 2900 км шилэн кабель, 700 гаруй км аналог болон 2900 шахам км тоон технологийн радио релейний шугам, төлөвнз, радио өргөн нэвтрүүлэг, сансрын холбооны VSAT станцын сүлжээнүүдээс бүрдэж байна. Улаанбаатар хот, 21 аймгийн төв, томоохон хот, суурин газруудад суурин телефоны 146 214, хөдөлгөөнт телефоны 450 000, интернэтийн 220 000 хэрэглэгч тус тус бүртгэгдээд байна.

Улс хоорондын цахилгаан холбооны сүлжээ нь 100 хувь, хот хоорондын дамжуулах байгууламж үндсэндээ хотын төвийн сүлжээ нь 100 хувь тус тус тоон технологид шилжсэн бөгөөд цахилгаан холбооны үйлчилгээг Монголын цахилгаан холбоо ХХ, Төмөр замын зэрэг эрхлэх газар, Мобиком, Скайтел зэрэг компаниуд явуулж чөлөөт өрсөлдөөнд орсноор үнэ тариф 3-4 дахин хямдраад байна.

2004 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээгээр дунджаар 100 хүнд 6.4 суурин, 18.4 хөдөлгөөнт телефон цэг тус тус оногдож байна.

2001 онд Монгол Улсын 1050 багийг сум, аймгийн төвтэй холбосон тусгай зориулалтын радио холбооны сүлжээг байгуулж эмнэлгийн түргэн тусламж дуудах, байгалийн хүндрэл бэрхшээл тохиолдох, гэнэтийн осол болох зэрэг үед ашиглаж байна.

Монголын Телевизийн өргөн нэвтрүүлгийг сансрын ИНТЕЛСАТ хиймэл дагуулын тусламжтай хот, орон нутагт дамжуулж байна. 2004 онд сансрын телевизийн дамжуулах байгууламжийг тоон системд шилжүүлснээр төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр 4 телевизийн нэвтрүүлэг дамжуулах техникийн боломжийг бүрдүүллээ.

Улаанбаатар хот, аймгийн төвүүд, томоохон хот, суурин газарт кабель тооцоо болон MMDS технологи ашиглан нийт 14 аж ахуйн нэгж кабелийн телевизийн сүлжээ ажиллуулж байна. Улсын хэмжээнд кабелийн телевизтэй өрхийн тоо 50000 гаруй болоод байна.

Аймгийн төв болон суурин газруудад радио өргөн нэвтрүүлгийн станц 37 ажиллаж байгаагаас хэт богино долгионы (FM) нэвтрүүлэх станц 26-г дотоодын хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулаад байна. Улаанбаатар, Алтай, Мөрөн хотуудад богино долгионы радио нэвтрүүлэх станцыг 2003 онд ашиглалтад оруулснаар орон даяар 2 программын радио өргөн нэвтрүүлэг сонсох боломжтой болж хамрах хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлж сонсголын чанарыг сайжрууллаа. Улсын хэмжээнд 2003 оны байдлаар нийт 150000 өрх радиотой гэсэн судалгаа байдаг.

Улаанбаатараас аймгийн төв хүртэл 7 хоногт 2-5 удаа шуудан тээвэрлэж байгаагаас гадна шуудан холбооны уламжлалт болон шинэ төрлийн үйлчилгээг эрхлэн явуулж байна.

5.3. Үйлчилгээ, хэрэглээ Монгол Улсад анх 1994 онд цахим шуудангийн үйлчилгээ, 1996 оноос интернэтийн үйлчилгээ нэвтэрч одоогоор Мэйжинэт, Миком, Бодиком, Эм-Си-Эс, Эрдэмнэт, Мобиком, Скай Си энд Си, Рейлком, WiNet зэрэг 9 компани интернэтийн үйлчилгээг эрхэлж байна.

Монголын интернэтийн гадаад гарцын зурвасын өргөн нь одоогийн байдлаар 78 Мб/с, үүнээс хүлээн авах нь 44 Мб/с, дамжуулах нь 34 Мб/с байна.

Төрийн мэдээллийг электрон хэлбэрээр олон нийтэд хүргэх ажил эрчимтэй явагдаж байна. Үүний нэг жишээ бол Монгол Улсын Төрийн байгууллагуудын вэб хуудас www.pmt.gov.mn, Ерөнхий сайдын ажлын албаны www.open-government.mn вэб хуудсууд юм. Монгол агуулга бүхий вэб хуудсууд нь .mn болон бусад домэйн (.com, .org, .net... г.м) нэрээр интернэтэд байрлаж байна. Судалгаагаар идэвхтэй ажиллаж буй 1 500 гаруй монгол вэб сайт байгаагаас 73.6 хувь нь ".mn" домэйн нэрийн дор дотоодын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн вэб сервер дээр байрлаж байна. Нийт вэб сайтуудын 50.4 хувь нь хувийн хэвшилийнхэнд, 30.7 хувь нь төрийн бус байгууллагуудад, 9.8 хувь нь хувь хүмүүст, 9.1 хувь нь төрийн байгууллагуудад ногдож байна.

"Мэдээллийн технологийн үндэсний парк"-ийг БНСУ-ын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр байгуулж, 2003 онд ашиглалтад бүрэн орууллаа. Уг парк нь аж ахуйн нэгжийг шалгаруулан мэдээллийн технологийн инкубаторын үйлчилгээнд хамруулж байна. Инкубаторт байрлах аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүй байраар хангагдах, интернэтийн нэгдсэн холбоотын төлбөрөөс 70 хувь хөнгөлөлт эдлэх, паркийн зүгээс менежментийн аж бүрэн дэмжлэг авах зэрэг боломжтой боллоо. Үүний үр дүнд программ хангамжийн чиглэлээр 100 гаруй компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанар эрс сайжирч байна.

Монгол Улсад цахим-арилжаа, цахим-банкны чиглэлээр сүүлийн жилүүдэд тодорхой дэвшил гарч байна. Арилжааны банкууд картын системийг үйлчилгээндээ нэвтрүүлсэн нь э-арилжаа, э-бизнесийн орон зайн хөгжилд түлхэц үзүүлээд. Одоогийн байдлаар 300 гаруй дэлгэр, зочид буудал, ресторан, томоохон үйлчилгээний газрууд, шатахуун түгээх төв, аялал жуулчлал, онгоцны тийзийн газруудад зээлийн болон дебет картны үйлчилгээ нэвтрээд байна.

5.4 Хүний нөөцийн хөгжил Өнөөдөр МХХТ-ийн салбарт мэргэжилтэн бэлтгэдэг 12 их, дээд сургууль, коллежид 3000 гаруй оюутан суралцаж, компьютерийн программ болон техник хангамж, мэдээллийн систем, мэдээллийн системийн менежмент, мэдээллийн сүлжээ, цахилгаан болон радио холбоо, телевизийн техник, мэдээллийн технологи гэсэн мэргэжлээр сургалт явуулж бакалавр, магистр, докторын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж байна. Дээрх сургуулиудыг холбооны инженер мэргэжлээр 1600 гаруй, компьютерийн программ болон техник хангамжийн мэргэжлээр 1500 гаруй хүн төгссөн байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас өндөр хөгжилтэй орнуудад МХХТ-ийн чиглэлээр магистрантур, докторантурт оюутан суралцах бодлогыг түлхүү баримталж байна.

Мэдээллийн технологийн үндэсний паркийг байгуулснаар мэдээллийн технологийг улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл болгох зорилтыг хэрэгжүүлэх, далхий дахинд өрсөлдөх чадвартай салбар болгон хөгжүүлэх, мэдээлэл, холбооны технологийн талаар төрөөс баримталж байгаа хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх боломж бүрдэх юм. "Мэдээллийн технологийн парк байгуулах", "Мэдээллийн технологийн сургалтын төв байгуулах" зэрэг чухал зорилт хэрэгжлээ. 2002 онд Холбоо мэдээллийн сургалтын төвийг байгуулан ажиллуулснаар мэдээллийн технологийн боловсон хүчнийг сургах, давтан сургах чадавхийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой алхам болж байна.

Түүнчлэн программчлал, интернэт, мэдээллийн сүлжээ зэрэг чиглэлээр Cisco, Microsoft, Sun Microsystems компаниудын итгэмжлэгдсэн урт, богино хугацааны сургалтуудыг явуулж байна.

6. Хөтөлбөрийн хамрах хүрээ

МХХТ-ийг дунд хугацаанд хөгжүүлэхэд дараах чиглэлийг баримталж байна. Үүнд:

1. Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх
2. МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх
3. МХХТ-ийг засаглал болон бусад салбарт хэрэглэх эдийн засаг, бизнесийн орчин, бусад хэрэглээг бүрдүүлэх

4. МХХТ-ийг эрчимтэй хэрэглэх хүний нөөцийг хөгжүүлэх

Дээрх чиглэлийн дагуу "Цахим Монгол" хөтөлбөрийг дараахь үндсэн стратегид хуваан үзэж болно:

МХХТ-ийн хөгжлийн зорилт	"Цахим Монгол" хөтөлбөрийн МХХТ-ийн хөгжлийн стратеги
Хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх	1.1 МХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэтгэл хийх 1.2 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх 1.3 Цахилгаан холбооны салбарыг либеральчлах
МХХТ-ийн дэд бүтцийг хөгжүүлэх	2.1 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх 2.2 Хүртээмжтэй, хямд мэдээлэл, холбооны үйлчилгээг хөгжүүлж тоон ялгааг арилгах 2.3 Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, санг байгуулах 2.4 Бүх нийтийг компьютержүүлэх 2.5 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
МХХТ-ийг нийгмийн бүх салбарт хэрэглэх	3.1 Төрийн дэмжлэг, манлайлаар хангах 3.2 МХХТ-ийг ашиглан төрийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэчлэл хийх МХХТ-ийн хэрэгтээ (application), түүний харилцан уялдаа 3.3 Цахим засаглалыг хөгжүүлэх 3.4 Цахим боловсролыг хөгжүүлэх 3.5 Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх 3.6 Цахим арилжааг хөгжүүлэх 3.7 Стандарт МХХТ-д тулгуурласан эдийн засгийн өсөлт 3.8 Эдийн засгийн салбарт МХХТ-ийн хөрөнгө оруулалт болон хэрэглээг хурдасгах, дэмжих 3.9 Жижиг, дунд үйлдвэр болон аж ахуйн нэгжүүдэд МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, дэмжих 3.10 МХХТ-ийн дотоодын ажил, үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх 3.11 МХХТ-ийн дотоодын компаниудын экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх МХХТ-ийг олон нийтэд таниулах, иргэдийн оролцоо 3.12 Олон нийтэд МХХТ-ийг танин мэдүүлэх 3.13 Олон нийтийг хамарсан сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх 3.14 Төр засгийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
Хүний нөөцийг хөгжүүлэх	МХХТ-ийг ашиглах чадвар, хүний нөөцийн хөгжил 1.1. Хүн бүрт МХХТ-ийг эзэмшүүлэх, дадал олгох 1.2. Төрийн албан хаагчдын МХХТ-ийн боловсролыг дээшлүүлэх 1.3. МХХТ-ийн мэргэшлийн мэргэжилтэн, судлаачид бэлтгэх

7. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Цахим Монгол хөтөлбөрийн МХХТ-ийн хөгжлийн стратегийн үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах үр дүн, авах арга хэмжээ, хариуцах байгууллага:

7.1 Хууль эрх зүй, бодлого зохицуулалтын орчин

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1. МХХТ-ийг хөгжүүлэх хууль эрх зүйн шинэтгэл хийх	МХХТ-ийн багц хууль батлагдан гарч МХХТ-ийн хөгжлийн таатай орчин бүрдэнэ Цахим засаглал хөтөлбөрийн бодлого тодорхой болно МХХТ-ийг ашиглан иргэдэд үзүүлэх төр засгийн үйлчилгээг онлайн хэлбэрт оруулснаар иргэдийн 30% энэ үйлчилгээг хүртэнэ Цахим арилжааны үндэсний эдийн засагт эзлэх хувь 10%-д хүрнэ	1) Мэдээллийн технологийн багц хуулийн төслийг боловсруулах 2) Мэдээллийн технологийн багц хуулийг УИХ-аар батлуулах 1) Үүнтэй уялдуулан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах 2) Цахим арилжаатай холбоотой хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах	2005-2006 2006 2005-2006 2006-2007	ХЗДХЯ, МХХТГ, ХХЗХ

2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг (БНУС) бүрдүүлэх Тайлбар: МХХТ-ийн үйлчилгээ хүргэхэд бизнесийн ашиггүй, хүндрэлтэй алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд бүх нийтийн үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсан сан болно.	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх үйл ажиллагааг ойлгомжтой болгож туршилтын төслүүд хэрэгжинэ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр хөдөлгөөний нийт хүн амд үзүүлэх МХХТ-ийн үйлчилгээ 50 хүртэл хувиар нэмэгдэнэ	1) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх ажиллагааг боловсронгуй болгох 2) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх 3) Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хэрэгжилтийг зохион байгуулах	2005-2006 2005-2006 2006	СЯ, ХЗДХЯ, МХХТГ, ХХЗХ
3. Цахилгаан холбооны салбарыг либеральчлах	Цахилгаан холбооны салбар хувьчлагдана	1) Цахилгаан холбооны салбарыг либеральчлах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх 2) Холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах 3) Цахилгаан холбооны салбарын хувьчлалыг хийх	2005-2006 2006 2005-2006	СЯ, ХЗДХЯ, ТӨХ, МХХТГ, ХХЗХ

7.2 Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц

Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх Тайлбар: Өндөр хурдны сүлжээг байгуулахдаа бусад дэд бүтэцтэй уялдуулан хөгжүүлэхэд анхаарах, тухайлбал цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу OPGW төрлийн шилэн кабелийг ашиглах боломжийг судлах	- Бүх аймгийн төвүүд өндөр хурдны сүлжээнд холбогдоно - Бүх сум, суурин газрууд тоон сүлжээнд холбогдоно - Сумдын 30% шилэн кабелийн сүлжээнд холбогдоно - Сумдын 60% утасгүй тоон системд холбогдоно - Сумдын 5% сансрын холбоогоор холбогдоно	- Суурь сүлжээнд тулгуурлан IP протоколд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг байгуулах - ОХУ, БНХАУ-тай холбогдсон олон улсын өндөр хурдны өргөн зурвасын (broadband) мэдээлэл холбооны газрын сүлжээ байгуулах - МХХТ-ийн дэд бүтцэд хувийн хэвшлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх - Төрийн эзэмшилд байгаа болон төрийн өмч давамгайлсан мэдээлэл холбооны үндсэн сүлжээнд тулгуурласан үйлчилгээний бизнесийг үе шаттайгаар хувьчлах - Мэдээлэл холбооны сүлжээнд нээлттэй, ялгаваргүй холбогдох, шударга өрсөлдөөний зохицуулалт бүхий зах зээлийн орчинг бүрдүүлэх - Улсын нэгдсэн сүлжээг ашиглах, түрээслэхтэй холбогдсон харилцаанд байгаа зарим монопольт байдлыг халж чөлөөт өрсөлдөөнийг нэвтрүүлэх - Дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдсан хамгийн орчин үеийн утасгүй мэдээлэл холбооны дэвшилтат технологи болон үүрэн телефоны дараагийн үеийг нэвтрүүлэх Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлж телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	2006-2012 2005-2007 2005-2010 2005-2008 2005-2006 2005-2006 2006-2010 2005-2012	СЯ, УМХГ, МХХТГ, ХХЗХ, МЦХХК
2.Хүргээмжтэй, хямд, найдвартай холбооны үйлчилгээг хөгжүүлж тоон ялгааг арилгах	100 хүнд ноогдох телефон утасны нятралаар Ази тивдээ эхний - аравт орно - Орон нутагт телефон цагийн нягтрал 15%-д хүрнэ 2012 он гэхэд бүх аймаг, сум интернет холболттой болно - Сумдын 65%-д хөдөлгөөнт холбооны үйлчилгээ нэвтэрнэ	- Хөдөлгөөний иргэдэд хүрэх МХХТ-ийн үйлчилгээг туран шуудай хямд үнээр хүргэх дэвшилтат технологийг нэвтрүүлэх - Зарим радио давтамжийн зурвасыг тусгай зөвшөөрөлгүй болгох - Харилцаа холбооны салбарыг сүлжээний болон үйлчилгээний чиглэлээр салгаж бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх - Малчдад мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх - Гэрийн эзэгтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан МХХТ-ийн үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулах, энэ чиглэлээр тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх - Ядуурал, амьжиргааны тогтмол эх үүсвэртэй болоход мэдээллийн технологийг өргөнөөр ашиглах, бага орлоготой өрхийг компьютержүүлэх	2006-2012 2007-2010 2005-2009 2006-2012 2006-2008 2006-2008	СЯ, ХХААЯ, НХХЯ, МХХТГ, УМХГ, ХХЗХ, МЦХХК

3. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, санг байгуулах Тайлбар: Төрийн өндөр хурдны мэдээллийн сүлжээ нь Цахим засаглал хөтөлбөрийн хэрэглэнүүдийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, санг байгуулагдана Өндөр хурдны мэдээлэл холбооны хотын сүлжээ байгуулагдана	1) Төрийн өндөр хурдны мэдээллийн сүлжээг байгуулж Улаанбаатар хотын болон үндэсний сүлжээнд холбох 2) Томоохон хот суурин газруудад төрийн болон ТББ, хувийн хэвшлийг холбосон өндөр хурдны сүлжээ байгуулах 3) Төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах	2007-2008 2005-2010 2007-2010	СЯ, МХХТГ, ХХЗХ, УМХГ, ТХГ, МЦРХХ
4. Бүх нийтийг компьютержүүлэх	2012 онд 6-гаас дээш насны нийт хүүхдийн 80% компьютер ашиглах чадвартай болно 2012 онд дунд сургуулийн 10 хүүхэд тутмын нэг нь компьютер ашиглах болно 2012 он гэхэд багш бүр компьютертэй болно 2012 онд бүх сумдын 70%, бүх аймгууд зайны сургалтад хамрагдах болно	1) Бүх нийтийн компьютержүүлэлт төслийг хэрэгжүүлэх 2) Импорттор оруулж ирэх компьютер, түүний дагалдах техник, хэрэгслүүдийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тааламжтай нөхцөлийг бий болгох 3) Дотоодод компьютер үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг дэмжих 4) Иргэд, байгууллагуудад компьютер, техник хэрэгслийг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, зээлийн эргэн төлөх хувилбаруудыг банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 5) Хэрэглээнийхээ шаардлагаас хамааруулан техник хэрэгслээ сайжруулж буй иргэн, байгууллагуудтай гэрээ хийж, сольж байгаа техник хэрэгслийг нь шилжүүлэн хэрэглэх зарчмыг баримтлах 6) Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан компьютержүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2005-2008 2005-2006 2006-2007 2005-2006 2006-2008 2006-2008	СЯ, Монгол банк, МХХТГ, ТЕГ, УГЕГ, МТЗ, МХАУТ, УСГ, нийслэл, аймгийн ЗДТГ, ХЭАХХ
5. Мэдээллийн аюулгүй байдлыг/МАБ/ хангах	Хууль эрх зүйн таатай орчин бий болно МАБ-ын бодлого тодорхойлогдоно МАБ-ын стандартууд батлагдана МАБ-ын технологийн орчин бүрдэнэ Иргэд цахим орчны талаар итгэлтэй болно	1) Цахим мэдээлэл солилцох, санхүүгийн гүйцгээ хийх зэрэг сүлжээгээр дамжиж иргэд, байгууллага хоорондын харилцааны аюулгүй байдал, харилцан итгэлцлийг хангахын тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох 2) Мэдээлэл алдагдах, мэдээллийг өөрчлөхөөс хамгаалсан хууль, эрх зүйг боловсронгуй болгох 3) МАБ-ыг хангах бодлого боловсруулах 4) Мэдээллийн нууцлалаас хамааруулан хамгаалалтын түвшинг (security level of protection) тогтоох 5) Мэдээллийн аюулгүй байдлын технологийн үндэсний стандартыг (information security technology standartization) боловсруулах 6) МАБ-ыг хангах нууцлал (cryptography), хамгаалах болон хяналтын систем (firewall, intrusion detection), программ хангамж, техник хэрэгслийн үнэлгээ хийх 7) МАБ-ыг хангах, кибер довтолгоонтой тэмцэх хамтын ажиллагааг хөгжүүлэх 8) МАБ-ын талаар олон нийтэд өргөнөөр сурталчлах 9) МАБ-ын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх	2006-2008 2006-2007 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008 2006-2008	ХЗДХЯ, МХХТГ, ТЕГ, ТХГ
7.3 Манлайлал, шинэчлэл				
Хэрэгжүүлэх стратеги	Гарах үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага

1. Төрийн дэмжлэг, манлайллаар хангах	Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт МХХТ-ийн асуудал хариуцсан мэдээллийн удирдах ажилтан (бүтэц)-тай болно. МХХТ-ийн бодлогын хэрэгжилтийг хангах бололцоо бүрдэнэ	1) Засгийн газрын үйл ажиллагааны нөхцөлбөртэй уялдуулан МХХТ-ийн бодлого боловсруулах 2) МХХТ-ийн бодлого хэрэгжилтийн удирдамжаар хангах 3) Төрийн бүх шатны байгууллагад МХХТ-ийн асуудал хариуцсан удирдах ажилтан (бүтэц) томиж, МХХТ-ийг хөгжүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд салбар хоорондын ажлын уялдааг сайжруулах 4) Засгийн газарт МХХТ-ийн бодлогын зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий Ерөнхий сайдаар ахлуулсан орон тооны бус МХХТ-ийн Үндэсний хороог ажиллуулах 5) Үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг бий болгож, олон нийтийг бодлого, хэрэгжилтэд оролцох бололцоог бүрдүүлэх 6) Хэрэгжүүлэх стратеги бүрийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	2006-2007 2006-2007 2006 2006 2006 2006	Яам, агентлаг, МХХТГ, МХХТ-ийн холбоод
2. МХХТ-ийг ашиглан төрийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, шинэчлэл хийх	Төрийн байгууллагуудад МХХТ-ийг нэвтрүүлэх үүрэг бүхий бүтэц бий болго Засгийн газраас МХХТ-ийг ашигласан ажил хэргийн үйл явцын шинэ хэлбэр, загварыг бий болгож, хэрэгжүүлнэ Төрийн ажилтнуудын МХХТ-ийг ажлын байрандаа ашиглах хандлагад өөрчлөлт орно	1) Төрийн удирдлага, үйл ажиллагааны шинэчлэлийг хэрэгжүүлэх хороо байгуулах 2) Шинэчлэлтийн талаар заавар, санал зөвлөмж өгөх дэд хороог байгуулах 3) Шинэчлэлтийн хэрэгжилтийг хянах дэд хороог байгуулах 4) Шинэчлэлтийн хэрэгжилтийг цаг хугацаа, хэмжих аргачлалын дагуу захирамж удирдамжаар хангах	2006 2006 2006 2006	Яам, агентлаг, МХХТГ

7.4. МХХТ-ийн хэрэглээ, түүний харилцан уялдаа

Хэрэгжүүлэх стратеги	Гэрэх үр дүн	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх Хугацаа	Хариуцах байгууллага
